



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ**

Нам Ян Жугийн гудамж 32/1,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13335
Утас: 45 39 94, Факс: (976-11) 45 86 99,
Цахим шуудан: info@nccd.gov.mn,
Цахим хуудас: www.nccd.gov.mn

2025.01.22 № 3-3/83

танай _____-ны № _____-т

Үнийн санал авах тухай

Тус төвөөс Сүрьеэгийн тандалт судалгааны албаны лавлах лабораторийн хэрэгжүүлж буй “Уушгины сүрьеэтэй хүүхдийн өтгөний сорьцод Xpert Ultra assay шинжилгээ хийх аргыг нэвтрүүлэх үйл ажиллагаа”-ны үнэлгээний хүрээнд нийт сүрьеэгийн сэжигтэй 100 хүүхдийн рентген шинжилгээний үр дүнг унших болон эмнэлзүйн зөвлөгөө өгч, онош баталж үр дүнг хэлэлцэх, ажлыг гүйцэтгэх гэж байгаа тул “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дах заалтын дагуу энэхүү ажлыг гүйцэтгэхтэй холбоотой хувь хүний анкетыг ажлын 5 хоногт багтаан 2025 оны 1 -дугаар сарын 27 -ны өдрийн дотор tender@nccd.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хавсралт хуудастай.

ДЭД ЗАХИРАЛ



Б.САРУУЛ

Халдварт Өвчин Судлалын Үндэсний
Төвийн 2025 оны 3.31.83 дугаартай
албан бичгийн хавсралт



“Уушгины сүрьеэтэй хүүхдийн өтгөний сорьцод Xpert Ultra assay шинжилгээ хийх аргыг нэвтрүүлэх үйл ажиллагаа”-ны хүрээнд нийт сүрьеэгийн сэжигтэй 100 хүүхдийн рентген шинжилгээний үр дүнг унших болон эмнэлзүйн зөвлөгөө өгч, онош баталж үр дүнг хэлэлцэх ажлыг гүйцэтгэх

Эхлэх хугацаа: 2025 оны 01 сарын 20

Дуусах хугацаа: 2025 оны I улирал

1.	Хамрах хүрээ	Дүрс оношилгооны эмч нар
2.	Үнэлгээ хийх хувь хүнд тавигдах шаардлага	1. Хүний их эмч 2. Дүрс оношилгооны эмчээр нарийн мэргэшил эзэмсэн байх 3. Мэргэжлийн ахлах болон түүнээс дээш зэрэгтэй 4. Сүрьеэгийн чиглэлээр мэргэжлийн үзлэг, зөвлөгөөг бусад эмнэлгүүдэд өгөх чадвартай 5. Дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх 6. Багаар ажиллах чадвартай байх
3.	Тайлангийн хуваарь	Гэрээ байгуулж ажил гүйцэтгэж эхэлсэн өдрөөс хойш 30 хоног тутамд ажлын явц үр дүнг тайлагнаж байна.
4.	Хүлээгдэж буй үр дүн	Нийт сүрьеэгийн сэжигтэй 100 хүүхдийн рентген шинжилгээний үр дүн болон эмнэлзүйн талын зөвлөгөө өгч, онош батлах мөн баасны сорьцыг шингэрүүлэн Xpert MTB/RIF ultra шинжилгээний аргын дүнг үнэлж, өдөр тутмын практикт нэвтрүүлэх
5.	Гүйцэтгэх ажлын шаардлага	Үнэлгээний тохиолдлуудыг хэлэлцэх эмнэлзүйн багийн гишүүдийн хурал зарлахад тогтмол оролцож асуудал хэлэлцэж шийдвэрлэх.
6.	Төлбөрийн нөхцөл	Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд холбогдох бүх зардал, татвар зэрэг багтсан багтсан байна. Гэрээн дээр ажлын хөлсийг тодорхой заасан болно. Ажлын хөлс: 1 хүүхэд х 4000 төгрөг Нийт 100 хүүхдийн эмнэлзүйн асуудал хэлэлцэх.
7.	Санал ирүүлэх	Шалгаруулалтыг хангасан этгээд дээрх бичиг баримтыг бүрдүүлэн tender@nccd.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.